

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН 2018 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАЙЛАН**

2018.03.20

Төвийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан нийтлэг 32, тусгай захиалгат 6, манлайллын зорилтыг хэрэгжүүлэх 13, нийт 51 арга хэмжээний хэрэгжилтийн байдал 2018.03.20-ны өдрийн байдлаар 63,8%-ийн биелэлттэй байна.

Хэрэгжилтийн явц /арга хэмжээгээр/

№	Бүтээгдэхүүн	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин							Хугацаа болоогүй	Өссөн дүн /%/
			100%	90%	70%	50%	30%	10%	0%		
1	Нийт арга хэмжээ	32	6	1	2	4	1	4	-	14	61,1
2	Тусгай захиалгат арга хэмжээ	6	-	-	-	-	1	3	-	2	15,0
3	Манлайллын зорилтын	13	-	9	1	-	-	-	-	3	88,0
Бүгд		51	6	10	3	4	2	7	-	19	63,8

Хэрэгжилтийн явц /хэлтсээр/

№	Хэлтэс	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн түвшин							Хугацаа болоогүй	Дундаж дүн /%/
			100%	90%	70%	50%	30%	10%	0%		
1	ХЗХБХ	16	2	-	-	1	1	3	-	9	44,3
2	ТМССХ	13	-	4	-	2	1	4	-	2	48,2
3	ЗСХ	18	3	6	3	1	-	-	-	5	84,7
4	Хамтран хийх	4	1	-	-	-	-	-	-	3	100
Бүгд		51	6	10	3	4	2	7	-	19	63,8

Удаашралтай байгаа арга хэмжээ:

1. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх;

2. Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлах;

3. Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага. MNS 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дугаарлалтыг шинэчлэх;

4. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарын саналыг нэгтгэн зохицуулалт хийх, монголын талаас зохион байгуулалттай нэгдмэл саналыг ТЗХАБ-ын зөвлөгөөнөөр дэвшүүлж, шийдвэрлүүлж байх зорилгоор Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын болон экспорт, импорт, транзит ачааны хэмжээг тохиролцох ТЗХАБ-ын 2017-2018 оны хуралд ажиглагчаар оролцох;

5. БНХАУ-ын Зүүн өмнөдийн Зам харилцааны их сургуультай хамтран ажиллаж, төвийн болон салбарын ажилтнуудыг богино хугацааны сургалтад хамруулах;

6. ГТХЗНТ-ийн нөөц удирдлагын төв /backup/-ийн барилга баригдах газрын асуудлыг шийдвэрлүүлэх;

7. Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, эрдэмтэн, докторуудын судалгаа, эрдэм шинжилгээний ажил, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх;

8. Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөх олон улсын болон Европын холбооны стандартуудыг орчуулан боловсруулах;

9. ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх;

10. ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын зураг төслийн ажил боловсруулахад захиалагчийн хяналт тавих, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүжүүлэх банкиг сонгож барилга угсралтын ажлыг эхлүүлэх, шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авах, инженер геологийн дүгнэлт хийлгэх;

11. Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох нийтлэг дүрмийг шинэчлэн боловсруулахад ТББ-тай хамтран ажиллах, тус дүрмийн дагуу сургалтыг зохион байгуулж ажиллах;

12. Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх чадамжид суурилсан сургалт зохион байгуулах, мэргэжлийн түвшин, зэрэг тогтоох, тасралтгүй мэргэжил дээшлүүлэх тогтолцооны бүдүүвчийг боловсруулах;

13. ГТХЗНТ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн боловсруулж батлах;

14. Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-д нийцүүлэн "Нууц хамгаалах журам" боловсруулж баталж мөрдөх;

15. ГТХЗНТ-ийн захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж батлуулах;

16. Шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан Ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээг чанд мөрдөх, мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Хугацаа болоогүй:

1. Төвийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн 1.1.4, 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.4, 2.3.5, 2.3.6, 2.3.7, 2.4.1, 2.4.2, 2.5.1, 3.4.4, 3.4.5, 3.8, 4.9, 5.2-т тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Санал зөвлөмж:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулах ГТХЗНТ-ийн төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний төсөл яамны ямар нэгжид хянагдаж байгаа, холбогдох нэгжүүд санал өгсөн эсэх, хэдийд албажиж баталгаажих талаар ЗТХЯ-наас лавлаж тодруулах;

2. Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлыг үе шат бүрд хуваарилан сар тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлэх;

3. Удаашралтай байгаа ажлуудыг "зорилтот түвшин"-д бүрэн хүргэхэд чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг салбарын байгууллагуудад танилцуулах уулзалт арга хэмжээ зохион байгуулагдаж буйтай холбогдуулан үзэл баримтлалын төсөлд нэмэлтээр санал тусгах;

5. Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн журмын төсөл боловсруулсны дараа төрийн захиргааны төв болон төмөр замын холбогдох байгууллагаас санал авах, үндэслэлтэй гэж үзвэл саналыг тусгах, журмыг батлуулах;

6. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зуны зурмагийн төслийг Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 4.1.1.3-т заасан хугацаанд бүрдүүлж хөдөлгөөний зуны нэгдсэн зурмаг боловсруулах бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг IY сард зохион байгуулж, нэгдсэн зурмагийн төслийг боловсруулах;

7. Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан 8 дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах арга хэмжээ үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй хэдий ч нэмэлт, ажил үйлчилгээнд тооцон ЗТХЯ-нд тайлагнаж үнэлүүлэх учир ЗТХ-ийн сайдын 2018 оны 13 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж буй төвийн төлөөллүүд идэвх санаачлагатай, ажлын хэсгийн ахлагч нартай эргэх холбоотой ажиллах;

8. Төмөр замын зүтгүүр, илчит тэргийн дугаарлалтыг шинэчлэх, “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага. MNS 6630-3:2016 стандарт”-ыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх, энэ асуудлаар ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ, ХШҮДАГ-аас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах;

9. Улсын хэмжээнд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ, ХШҮДАГ, “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Сайд, Төрийн нарийн бичгийн даргын эсхүл төвийн Захирлын тушаалаар байгуулах асуудлыг яамны холбогдох газрын удирдлагатай зөвшилцөж нэг мөр шийдвэрлэх;

10. Орчуулан боловсруулсан “Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж. Аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга” стандарт, O+P 941-Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” санамж, “Глобал навигацийн хиймэл дагуулын систем. Нийтийн хэрэглээний төмөр замын хүлээн авагч. Техникийн шаардлага” стандартын төслүүдийг төмөр замын болон ТББ-уудад хүргүүлж санал авах арга хэмжээг зохион байгуулах;

11. Дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх 3 журмын төслийг боловсруулах арга хэмжээ удаашралтай байгаад дүгнэлт хийж яаралтай батлуулах арга хэмжээ авах;

12. Үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах, шалгуур үзүүлэлтүүдийг хэрэгжүүлэх, төвийн цахим хуудас дахь зарим мэдээллийг шинэчлэх.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА